

20.1 Элсэлтийн цахим бүртгэлийн үйл ажиллагаа

Хамрах хүрээ

Нийслэлийн есөн дүүргийн төрийн өмчийн Ерөнхий боловсролын 144-н сургуулийн 1-р ангийн элсэлтийг “Боловсролын мэдээллийн технологийн төв” УТҮГ-ын **parent.edu.mn** эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан системд тулгуурлан **цахимаар** зохион байгуулна.

Хугацаа:

2020-08-03 -ны 09 цагаас 2020-08-28-ны 17 цаг хүртгэл

Элсэлтийн цахим бүртгэлийн үйл ажиллагаа

1. Эцэг эх, асран хамгаалагч өөрөө цахимаар ЕБС -д бүртгүүлэх хүсэлт гаргах боломжтой. Мөн сургууль дээрх бүртгэлийн ажилтнаар дамжуулан бүртгэл хийлгэж болно.

2, 3, 4 Сургуулийн түвшинд элсэх хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлээд эцэг эх, асран хамгаалагчид хариу мэдэгдэнэ.

Цахимаар бүртгүүлэх хүсэлт илгээх хэлбэрүүд

1. PARENT.EDU.MN веб сайт
2. МОБАЙЛ АПЛИКЕЙШН
3. СУРГУУЛЬ ДЭЭР БАЙРЛАХ БҮРТГЭЛИЙН АЖИЛТАН

20.2 Цахим бүртгэлийн шалгуур

Элсэлтийн цахим бүртгэлийн шалгуур 2020 - 2021 оны хичээлийн жил

- Зөвхөн Нийслэлийн 9 дүүргийн сургуулиудийн хамран сургах тойргийн хаягт хамаарах оршин суух

хаягтай хүүхдийн элсэх хүсэлтийг цахимаар бүртгэх боломжтой.

- 2014 оны 1 сарын 1 -нээс 2014 оны 12 сарын 31 -ний хооронд төрсөн хүүхэд бүртгүүлэх боломжтой.
 - ЕБС -д бүртгэлгүй/сурдаггүй 2010 оны 1 сарын 1-нээс 2013 оны 12 сарын 31 хооронд төрсөн хүүхэд цахим элсэлтэнд бүртгүүлэх
 - Орон нутгийн сургуульд элсэгчдэд хамран сургах тойргийн сургуульд хандана.
 - Гадаадын иргэн харьяатын хувьд элсэх хүсэлтийг цахимаар гаргах боломжгүй.
 - Элсэх хүсэлт илгээгдсэн хүүхдийг дахин бүртгэх боломжгүй.
 - ЕБС-д бүртгэлтэй сурагчийг элсэгчээр бүртгэх боломжгүй.
-

20.3 Сургууль дээр элсэлт баталгаажуулах, цуцлах

Боловсролын удирдлагын “Элсэх хүсэлт” модулийг сонгоно.

Элсэх хүсэлтийн бүртгэлийн модуль нь дараах бүтэцтэй байна.

1. Элсэлтийн хүсэлт нь “Хянагдаж байгаа”, “Батлагдсан”, “Цуцлагдсан” гэсэн 3 төрөлтэй байна. Төлвүүдээс сонголт хийж Элсэгчдийн жагсаалтыг шүүж харах боломжтой.
2. Элсэлтийн бүртгэлийн жагсаалт нь Элсэгч, Регистр, Хаяг, Хүсэлтийн төлөв, Огноо, Элсүүлэгч, Холбоо барих гэсэн мэдээллийг агуулна.
3. Элсэгчдийн жагсаалтаас хайлтын талбарууд дээр утга бичиж хайх боломжтой.

4. Жагсаалтаас суралцагчийн нэр бүхий мөрийг идэвхижүүлээд Элсэгчийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл харах боломжтой.

5. Жагсаалтаас суралцагчийн нэр бүхий мөрийг идэвхижүүлээд элсэлтийн шийдвэрийг **Баталгаажуулах** эсвэл **Цуцлах** үйлдэл гүйцэтгэн баталгаажуулна. Баталгаажуулах эсвэл цуцлах үед гаргасан шийдвэрийн талаар товч мэдээлэл бичих шаардлагатай ба Эцэг эхчүүд тухайн мэдээллийг харна.

6. Элсэлтийн бүртгэлийн жагсаалтыг **Экспорт** товч дээр дарж Эксел форматаар файл хэлбэрээр гарган авах боломжтой.

20.4 Эцэг эх хэрэглэгчийн эрх үүсгэх болон элсэгч бүртгэх

20.4 эцэг эх хэрэглэгчийн эрх үүсгэх болон 1-р ангид элсэгч бүртгэх заавар

Видео зааврыг дараах холбоосоор хандаж үзнэ

үү. <https://www.youtube.com/watch?v=u-6-wQE1WSE&feature=youtu.be>

Parent.edu.mn эсвэл мобайл аппликейшн ашиглан системд нэвтэрнэ.

Шинэ хэрэглэгч үүсгэх:

Бүртгүүлсэн и-мэйл хаягт баталгаажуулах код илгээсэн учир и-мэйл хаягаа шалгаж баталгаажилтыг идэвхижүүлнэ.

Бүртгэл амжилттай баталгаажсан тохиолдолд бүртгүүлсэн и-мэйл хаяг болон нууц кодоор системд нэвтрэн орно.

Гарч ирсэн хэсгээс эцэг эхийн мэдээлэл оруулах гэсэн товч дарна.

Эцэг эх өөрийн мэдээллээ оруулж хадгалах үйлдэл хийснээр нэгдүгээр ангид элсэгчийн бүртгэл хийх боломжтой болно.

Нэгдүгээр ангид элсэх хүсэлт гаргах:

Нэгдүгээр ангид элсэгчийн бүртгэл гэсэн хэсэгт нэвтэрч бүртгүүлэх гэсэн товч дарна.

Элсэх хүүхдийнхээ регистрийн дугаарыг оруулах шалгах гэсэн товч дарна.

Элсэгчийн мэдээллийг шалгасны дараа хүсэлт гаргагчийн мэдээллийг оруулж илгээх үйлдэл хийнэ.

Нэгдүгээр ангид элсэх хүсэлтийн жагсаалт болон төлөвийн мэдээлэл харагдана.
